



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хууль зүйн туслалцааны төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/234/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот</p> <p>2023 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn Ахлах аудитор: В.Эрдэнэцогт Утас: 263533 Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Захирал: Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com</p>
-----------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.02.24 № 07/374
танай _____-ны № _____-т

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ
ТӨВИЙН ДАРГА В.ОЮУМАА
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль зүйн туслалцааны төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хууль зүйн туслалцааны төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тайлант онд эд хариуцагч солигдох үед тооллого хийгээгүй, ажил хүлээлцсэн акт үйлдээгүй, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 30,846.3 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.2, 20.2.6 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаа, үр дүн ур чадварыг дүгнэхэд Хууль зүйн туслалцааны төвийн мэдээллийн нэгдсэн санг ашиглан өмгөөллийн хувийн хэргийн бүрдлийг үндэслэн батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж урамшуулал олгодог болсон байна.

Аудитын гол асуудал

Улсын Их Хурлын 2022 оны хаврын чуулганаар "Хууль зүйн туслалцааны тухай хууль"-ийг эцэслэн баталснаар 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үнэ

Z:\Yawsan_Bichig\2023\0224 -NAG-19.Docx

0001050639

төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцааг дан ганц эрүүгийн хэргийн яллагдагчаар хязгаарлахгүйгээр зарим төрлийн гэмт хэргийн хохирогч, эрх нь зөрчигдсөн болон гэрч хүүхэд, иргэн болон захиргааны зарим төрлийн хэрэг, маргааны төлбөрийн чадваргүй оролцогч, нэхэмжлэгчид үзүүлэхээр хуульчилж, хамрах хүрээг өргөжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувь гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,802,425.00	28,563,252.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,802,425.00	28,563,252.00
35400	Хангамжийн материал	18,802,425.00	28,563,252.00
35410	Бичиг хэргийн материал	865,540.00	6,509,881.00
35420	Аж ахуйн материал	17,753,785.00	20,814,371.00
35440	Түлш, шатах тослох материал	183,100.00	1,239,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	172,760,816.66	142,974,089.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	172,760,816.66	142,974,089.68
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	143,939,150.12	116,172,423.22
39203	Авто-тээврийн хэрэгсэл	77,068,664.92	146,143,664.92
39204	Хуримтлагдсан элэгдэл	(73,847,170.94)	(120,199,914.9)2
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	269,900,632.00	250,293,463.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(162,128,677.24)	(187,695,983.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,192,590.00	44,203,246.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,246,888.62)	(16,572,052.07)
39300	Биет бус хөрөнгө	28,821,666.54	26,801,666.46
39301	Программ хангамж	42,004,000.00	42,004,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(13,182,333.46)	(15,202,333.54)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	191,563,241.66	171,537,341.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	191,563,241.66	171,537,341.68
51	Засгийн газрын хувь оролцоо	191,563,241.66	171,537,341.68
51200	Хуримтлагдсан үр дүн	191,563,241.66	171,537,341.68
51210	Өмнөх үеийн үр дүн	229,590,587.84	191,563,241.66
51220	Тайлант үеийн үр дүн	(38,027,346.18)	(20,025,899.98)
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	191,563,241.66	171,537,341.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,145,336,700.00	1,265,696,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,145,108,700.00	1,222,483,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,145,108,700.00	1,222,483,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,145,108,700.00	1,222,483,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,183,364,046.18	1,285,721,999.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,183,364,046.18	1,285,721,999.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,179,561,169.30	1,200,040,342.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	843,469,396.00	852,536,300.30
210101	Үндсэн цалин	727,290,269.00	703,840,627.78
210102	Нэмэгдэл	62,911,904.00	97,149,854.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,165,223.00	12,590,317.33
210104	Урамшуулал	34,102,000.00	38,955,500.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,221,730.55	106,181,691.68
210201	Тэтгэврийн даатгал	67,299,830.55	67,448,423.16

210202	Тэтгэмжийн даатгал	10,230,500.00	10,042,988.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,184,400.00	7,831,915.33
210204	Ажилгүйдлийн даатгал	2,046,100.00	1,888,119.67
210205	Эрүүл мэндийн даатгал	20,460,900.00	18,970,245.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,888,040.00	86,016,326.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1,853,280.00
210302	Түлш, халаалт	0.00	1,323,666.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	582,160.00
210304	Байрны түрээс	107,888,040.00	82,257,220.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,088,356.57	34,853,947.68
210401	Бичиг хэрэг	9,206,890.00	7,474,759.00
210402	Тээвэр, шатахуун	8,088,000.00	6,334,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,202,531.57	9,603,597.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,358,355.00	11,281,491.00
210408	Бараа материал акалсны зардал	3,232,580.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,125,625.00	2,604,450.00
210604	Урсгал засвар	3,125,625.00	2,604,450.00
2107	Томилолт, зочны зардал	3,054,300.00	1,283,300.00
210702	Дотоод албан томилолт	3,054,300.00	1,283,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,886,700.00	30,637,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,187,800.00	25,604,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	499,300.00	420,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,900.00	126,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	122,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,866,700.00	2,964,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,827,021.18	85,926,826.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,024,400.00	9,935,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,802,621.18	75,991,226.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,802,876.88	85,681,657.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,419,200.00	14,035,387.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	11,735,387.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,419,200.00	2,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,383,676.88	71,646,270.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,383,676.88	71,646,270.34
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(38,027,346.18)	(20,025,899.98)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(38,027,346.18)	(20,025,899.98)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,145,108,700.00	1,222,483,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,145,108,700.00	1,222,483,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,145,108,700.00	1,222,483,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,145,108,700.00	1,222,483,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,128,153,700.00	1,219,491,600.00
299990	Устгал	0.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,128,153,700.00	1,219,491,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,124,350,823.12	1,133,809,942.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	843,469,396.00	852,536,300.30
210101	Үндсэн цалин	727,290,269.00	703,840,627.78
210102	Нэмэгдэл	62,911,904.00	97,149,854.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,165,223.00	12,590,317.33
210104	Урамшуулал	34,102,000.00	38,955,500.93
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,221,730.55	105,969,858.68
210201	Тэтгэврийн даатгал	67,299,830.55	67,448,423.16
210202	Тэтгэмжийн даатгал	10,230,500.00	9,831,155.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,184,400.00	7,831,915.33
210204	Ажилгүйдлийн даатгал	2,046,100.00	1,888,119.67
210205	Эрүүл мэндийн даатгал	20,460,900.00	18,970,245.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,888,040.00	86,228,159.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1,853,280.00
210302	Түлш, халаалт	0.00	1,535,499.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	582,160.00
210304	Байрны түрээс	107,888,040.00	82,257,220.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,101,931.57	44,614,774.68
210401	Бичиг хэрэг	9,167,200.00	11,882,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,691,800.00	7,390,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,202,531.57	9,603,597.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,040,400.00	15,578,677.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,462,325.00	2,604,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,336,700.00	0.00
210604	Урсгал засвар	3,125,625.00	2,604,450.00
2107	Томилолт, зочны зардал	3,054,300.00	1,283,300.00
210702	Дотоод албан томилолт	3,054,300.00	1,283,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,886,700.00	30,637,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,187,800.00	25,604,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	499,300.00	420,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,900.00	126,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	122,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,866,700.00	2,964,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,266,400.00	9,935,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,266,400.00	9,935,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,802,876.88	85,681,657.34

2132	Бусад урсгал шилжүүлэг	2,419,200.00	14,035,387.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	11,735,387.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,419,200.00	2,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,383,676.88	71,646,270.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,383,676.88	71,646,270.34
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	16,955,000.00	2,992,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,955,000.00	2,992,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,955,000.00	2,992,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,955,000.00	2,992,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,955,000.00	2,992,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-16,955,000.00	-2,992,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			229,590,587.84	229,590,587.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			229,590,587.84	229,590,587.84
Тайлант үеийн үр дүн			(38,027,346.18)	(38,027,346.18)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			191,563,241.66	191,563,241.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			191,563,241.66	191,563,241.66
Зарласан ногдол ашиг				
Тайлант үеийн үр дүн			(20,025,899.98)	(20,025,899.98)
2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл			171,537,341.68	171,537,341.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,252,483,600.00	1,150,837,329.66	101,646,270.34	91.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,252,483,600.00	1,150,837,329.66	101,646,270.34	91.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,238,441,300.00	1,136,801,942.66	101,639,357.34	91.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	928,429,600.00	852,536,300.00	75,893,300.00	91.8
Үндсэн цалин	719,955,300.00	703,840,627.78	16,114,672.22	97.8
Нэмэгдэл	148,933,300.00	97,149,854.26	51,783,445.74	65.2
Унаа хоолны хөнгөлөлт	19,239,000.00	12,590,317.33	6,648,682.67	65.4
Урамшуулал	40,302,000.00	38,955,500.93	1,346,499.07	96.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,912,000.00	106,181,691.68	21,730,308.32	83.0
Тэтгэврийн даатгал	84,420,100.00	67,448,423.16	16,971,676.84	79.9
Тэтгэмжийн даатгал	10,873,000.00	10,042,988.33	830,011.67	92.4
ҮОМШӨ-ний даатгал	8,698,400.00	7,831,915.33	866,484.67	90.0
Ажилгүйдлийн даатгал	2,174,600.00	1,888,119.67	286,480.33	86.8
Эрүүл мэндийн даатгал	21,745,900.00	18,970,245.19	2,775,654.81	87.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,348,700.00	86,016,326.00	1,332,374.00	98.5
Гэрэл, цахилгаан	1,880,000.00	1,853,280.00	26,720.00	98.6
Түлш, халаалт	1,720,000.00	1,323,666.00	396,334.00	77.0
Цэвэр, бохир ус	590,000.00	582,160.00	7,840.00	98.7
Байрны түрээс	83,158,700.00	82,257,220.00	901,480.00	98.9
Хангамж, бараа материалын зардал	44,704,500.00	44,614,774.68	89,725.32	99.8
Бичиг хэрэг	11,882,500.00	11,882,500.00	0.00	100.0
Тээвэр, шатахуун	7,391,400.00	7,390,000.00	1,400.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,603,600.00	9,603,597.68	2.32	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	160,000.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,667,000.00	15,578,677.00	88,323.00	99.4
Эд хогшил, урсгал засварын зардал	5,702,100.00	5,596,450.00	105,650.00	98.1
Багаж, техник, хэрэгсэл	3,023,400.00	2,992,000.00	31,400.00	99.0
Урсгал засвар	2,678,700.00	2,604,450.00	74,250.00	97.2
Томилолт, зочны зардал	1,283,300.00	1,283,300.00	0.00	100.0
Дотоод албан томилолт	1,283,300.00	1,283,300.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,071,800.00	30,637,500.00	2,434,300.00	92.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,914,100.00	25,604,700.00	2,309,400.00	91.7

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	420,200.00	420,200.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	126,100.00	126,100.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	84,000.00	22,000.00	62,000.00	26.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,964,800.00	2,964,500.00	300.00	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	62,600.00	0	62,600.00	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	9,989,300.00	9,935,600.00	53,700.00	99.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,989,300.00	9,935,600.00	53,700.00	99.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,042,300.00	14,035,387.00	6,913.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	14,042,300.00	14,035,387.00	6,913.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,736,000.00	11,735,387.00	613.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,306,300.00	2,300,000.00	6,300.00	99.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,252,483,600.00	1,150,837,329.66	101,646,270.34	91.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,252,483,600.00	1,150,837,329.66	101,646,270.34	91.9
Улсын төсвөөс санхүүжих	1,252,483,600.00	1,150,837,329.66	101,646,270.34	91.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	72	72	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	68	68	-	100.0
Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40,706.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 30,846.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 9,859.8 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 2,050.7 мянган төгрөгийн цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шаардаж бүрдүүлээгүй, татварын цахим хуудас дахь НӨАТ-ын баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлээгүй	1	2,050.7					1	2,050.7				
Цалингийн цэсийн дүнг ерөнхий журналын дүнтэй тулган шалгахад 573.2 мянган төгрөг, ХХОАТ-ын тайлангийн дүнтэй тулган шалгахад 468.4 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.	1	1,041.6					1	1,041.6				
Шатахууны зарцуулалтыг шалгахад автомашины спидометрийн заалт зөрүүтэй, 100 км-т зарцуулах шатахууны норм нормативаар тооцоогүй, аудитын давтан тооцоололтоор 617.5 мянган төгрөгийн шатахууныг илүү зарлагдсан байна.	1	617.5					1	617.5				
Тайлант онд эд хариуцагч солигдох үед тооллого хийгээгүй, ажил хүлээлцсэн акт үйлдээгүй, жилийн	1	30,846.3			1	30,846.3						

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 30,846.3 мянган төгрөгийн зөрүүтэй												
Дүн	4	34,556.1			1	30,846.3	3	3,709.8				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Шилэн дансны болон бусад хууль тогтоомжийн заалттай нийцээгүй зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 1 мэдээллийг мэдээлээгүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	6,150.0					1	6,150.0
Дүн	1	6,150.0					1	6,150.0